

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг
зохицуулах зөвлөлийн 2015 оны тайлан

2015 оны 12 дугаар сарын 17

Улаанбаатар хот

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2015 оны анхны хурлыг 2015 оны 2 дугаар сарын 17-ны өдөр хуралдуулж, зөвлөлөөс 2014 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн баталсан.

Төлөвлөгөө боловсруулахдаа тухайн онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нийтийн дэг журам хамгаалах асуудлаар юунд анхаарч, ямар ажил зохион байгуулах талаар Зохицуулах зөвлөлийн гишүүд, Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс, тасгаас санал авч төлөвлөгөөгөө боловсруулан батлуулсан. Төлөвлөгөөг газар, хэлтэс, тасагт хүргүүлж, улирал бүр тайлангаа ирүүлж байхаар албан бичгээр хүргүүлсэн. Тайлант жилийн хугацаанд Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс тайлангаа улирал бүр, Замын Цагдаагийн тасаг хагас жилээр ирүүлсэн.

2015 оны төлөвлөгөөнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл 4 удаа хуралдаж дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Үүнээс

- ❖ ГХУСАЗЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө -1
- ❖ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр газар, хэлтэс, тасгийн зохион байгуулсан ажил, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай -7
- ❖ ГХУСАЗЗ-ийн үйл ажиллагаа тайлан -1
- ❖ Тогтоол шийдвэр, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар 5 асуудал хэлэлцсэн.

/Зураг 1/

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2015 оны төлөвлөгөөний дагуу улирал бүр хуралдуулж, “Засаг даргын Тамгын газар, Онцгой байдлын болон Мэргэжлийн хяналтын хэлтсээс 2015 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон хяналтын чиг үүргээ хэрэгжүүлж буй байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” тайлан, Цагдаагийн 1, 2 дугаар хэлтсийн “Дүүргийн нутаг дэвсгэрт гарсан гэмт хэрэг, хэв журмын нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх ажлын тухай сонсгол”, Цагдаа-олон нийтийн хамтын ажиллагаа хөтөлбөр, Замын Цагдаагийн тасгаас Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2010 оны “Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай” 109 дүгээр тогтоолыг хэрэгжилт, “Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн дотоод сүлжээг шинэчлэх тухай”, “Зуслан” тусгай арга хэмжээ зохион байгуулах тухай асуудлуудыг хэлэлцэн тогтоол, тэмдэглэлээр үүрэг даалгавар өгч биелэлтийг тооцон ажилласан.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны төсвийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны зардлын ангилалд 50000000 /Тавин сая/ төгрөг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах нийслэлийн салбар зөвлөлөөс улирал бүр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилт 5750000 /Тав сая долоон зуун тавин мянга/ төгрөг, нийслэлээс жилдээ нийт 23000000 /хорин гурван сая/ төгрөгийн санхүүжилт хийгдэж 2015 оны дүүргийн зохицуулах зөвлөл 73000000 /далан гурван сая/ төгрөгийн төсөвтэй үйл ажиллагаа явуулсан.

Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс төлөвлөгөөнд тусгагдсан дараах ажлуудыг санхүүжүүлж гүйцэтгэлээ.

1. Цагаан сарын баярын өдрүүдээр нийтийн хэв журмыг сахиулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, архидан согтуурах болон орон

- байрны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, Замын Цагдаагийн тасгийн эргүүлийн автомашин 5 хоногийн нэмэгдэл шатахууны зардалд 3058200 төгрөг. /Зураг 2/
2. Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн 1 дүгээр улирлын гэмт хэргийн дүн мэдээг хэлэлцээд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 1 сарын аян”-ыг зохион байгуулахаар шийдвэрлэж 9386000 төгрөг /Зураг 3/
 3. Хороодын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга, Цагдаагийн хэсгийн байцаагч нарт зориулсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлье” сэдэвт сургалтад 170000 төгрөг /Зураг 4/
 4. Урин дулаан болж иргэд зусландаа гарч, амралт зугаалгын үе эхэлж байгаатай холбогдуулан иргэдэд цагдаагийн байгууллагын үйлчилгээг шуурхай хүртээмжтэй хүргэх, гэмт хэрэг зөрчил, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх түүнтэй тэмцэх зорилгоор зуслангийн авто замын уулзваруудад Цагдаагийн 2 дугаар хэлтсээс 24 цагийн пост 1, эргүүлийн автомашин 2, 3 мотоциклийг 2015 оны 6 дугаар сарын 15-ны өдрөөс 2015 оны 8 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл 76 хоног ажиллуулахад шаардлагатай шатахууны зардал 5160960 төгрөг /Зураг 5/
 5. Дүүргийн зуслангийн чиглэлийн ойн бүсээс хууль бусаар мод бэлтгэгчид, ховор нэн ховор ан амьтан агнах, ногоон бүсэд үйл ажиллагаа явуулахаар зөвшөөрөл авсан нөхөрлөлүүдийн үйл ажиллагаатай танилцах, байгаль хамгаалагчдад мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх зорилгоор хийсэн Мэргэжлийн хяналтын хэлтсийн 1 сарын хугацаанд хийх шалгалтын шатахууны зардал 1152750 төгрөг
 6. Цагдаагийн 1, 2 дугаар хэлтсийн дотоод сүлжээний аюулгүй байдал, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор дотоод сүлжээ байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийн зардалд 7150000 төгрөг
 7. Онцгой байдлын хэлтсээс тусгай 29 дүгээр сургууль дээр гамшгийн осолын үед авах арга тухай, гэр хорооллын иргэдэд галын аюулаас урьдчилан сэргийлэх зэрэг 2 удаагийн өдөрлөг, сурталчилгаа зохион байгуулах 2705000 төгрөгүүдийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны зардлаас шийдвэрлэж хяналт тавьж ажилласан.
 8. Шинэ жилийн баяраар нийтийн хэв журмыг бэхжүүлэх, архидан согтуурахтай тэмцэх, иргэдийг осгож эндэх болон зам тээврийн осолоос урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, Замын Цагдаагийн тасгаас нэмэлтээр ажиллах 19 эргүүлийн автомашиныг 2015 оны 12 дугаар сарын 21-ны өдрөөс 2016 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийг хүртэл 14 хоног ажиллуулах 5367840 төгрөг.
 9. Дүүргийн нутаг дэвсгэрийн төрийн болон төрийн бус байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулж буй ажлыг нэгтгэн чиглүүлэх, хамтын ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, залуучуудад зөв төлөвшил тогтох зорилгоор их, дээд сургуулиудын оюутнууд болон ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнуудад зориулан зохион байгуулахад 3470000 төгрөг. Уг сургалт нь МУИС, ШУТИС, Этүгэн гэх мэт сургуулиудаар үе шаттайгаар зохион байгуулагдаж байна. Цаашид ЕБС-иудаар зохион байгуулна. /Зураг 6/
 10. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, сургууль цэцэрлэг, иргэдэд замын хөдөлгөөний дүрэм, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийг сурталчилах, гэмт хэрэг, зам тээврийн осолоос урьдчилан сэргийлэх, нас насны ангилалд нь тохируулан санамж сэрэмжлүүлэг хэвлүүлэхэд 2900000 төгрөг

11. Дүүргийн Засаг даргын Тамгын газар дэргэдэх хэлтэс, тасаг, албадаас 2015 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлаараа шалгарсан Цагдаагийн 1 дүгээр хэлтсийг 5000000 төгрөгөөр, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2015 онд идэвх санаачлагатай, үр бүтээлтэй ажилласан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ажилтан Бямбасүрэнгийн Лхагвасүрэнг 1000000 төгрөг тус тус шагнасан.

2015 онд Зөвлөлөөс дээрх арга хэмжээнүүдийг санхүүжүүлэхэд 46,6 сая төгрөгийг зарцуулсан. Өнөөдрийн байдлаар төсвийн үлдэгдэл 26,4 сая төгрөг байна.

Мөн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл нь Улаанбаатар хотын Цагдаагийн газар, дүүргийн Прокурорын газар, Цагдаагийн 1,2 дугаар хэлтэстэй хамтран хороодын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийг чадавхжуулах тэдгээрийн ажлыг эрчимжүүлж, нийтийн хэв журмыг хангах ажлын арга туршлагыг нэмэгдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга барилыг боловсронгуй болгож үр дүнг дээшлүүлэх зорилгоор "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлье" сэдэвт сургалтыг 2015 оны 4 дүгээр сарын 02-ны өдөр зохион байгуулж дүүргийн 20 хорооны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга, хэсгийн байцаагч нарт хамрагдсан.

Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2015 оны тайланг улирал бүрийн 25-ны өдрүүдэд гаргаж нарийн бичгийн даргаар хянуулан зөвлөлийн даргаар баталгаажуулж нийслэлийн зохицуулах зөвлөлд хүргүүлэн ажилласан.



Зураг 1



Зураг 2



Зураг 3



Зураг 4



Зураг 5



Зураг 6

**ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ**